

ГАЗРЫН ДОР БОЛОН ХҮНД, ХОРТОЙ НӨХЦӨЛД АЖИЛЛАЖ БУЙ ИРГЭДИЙН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН АСУУДЛААРХ ӨРГӨДЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2014.10.08

Улаанбаатар хот

Иргэн Д.Орги, Г.Чимэгдэлгэр нарын ахмад уурхайчдаас “уурхайчид энгийн иргэдийн адил цалингийн 45 хувьтай тэнцэх хэмжээгээр өндөр насны тэтгэвэр тогтоолгодог бөгөөд дундаж тэтгэвэр 273 854 төгрөг байна. Уурхайчид газрын гүнд болон хүнд, хортой нөхцөлд олон жил ажилласнаас хууч өвчинтэй болж эмчилгээ сувилгаа шаардлагатай болдог. Иймд хөдөлмөрийн хүнд, хортой, өндөр эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэдэд бусад улсын жишгийг харгалзан газрын гүнд ажилласны нэмэгдэл, эсхүл нэг удаагийн нөхөн төлбөр олгож өгөх”-ийг хүссэн өргөдлийг Өргөдлийн байнгын хороонд ирүүлсэн байна.

Байнгын хорооны 2013 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 03 тоот тогтоолоор баталсан “Өргөдлийн байнгын хорооны гишүүдийн ажиллах чиг үүргийн хуваарь, өргөдөл шийдвэрлэх журам”-ын дагуу эдгээр өргөдлийг шийдвэрлүүлэхээр Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, С.Одонтуяа, М.Энхболд нарт хуваарилагдсаны дагуу судлан Байнгын хороонд танилцуулж байна.

Нэг. Өргөдлийг судалсан байдал

Уул уурхайд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэдэд төрөөс үзүүлж байгаа хөнгөлөлтийн хувьд энгийн иргэдээс эрт тэтгэвэр тогтоолгодог онцлогтой. Үүнийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт газрын дор болон хөдөлмөрийн хүнд, хортой нөхцөлд ажилласан жилээс хамааруулан өндөр насны тэтгэвэр тогтоолгох насыг өөр өөр буюу энгийн иргэдээс 5-10 жилийн өмнө байхаар заажээ.

Түүнчлэн Хөдөлмөрийн тухай хуулийн 97.1-д үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр өвчилсөн ажилтанд учирсан хохирлыг нөхөх зорилгоор үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд даатгуулсан эсэхийг үл харгалзан ажил олгогч нь хөдөлмөрийн чадвараа 30 хувь хүртэл алдсан ажилтанд 5 сар, 31-50 хувь алдсан ажилтанд 7 сар, 51-70 хувь алдсан ажилтанд 9 сар, 71 хувиас дээш алдсан ажилтанд 18 сарын цалингийн дундажтай тэнцэх хэмжээний нөхөн төлбөрийг нэг ба түүнээс дээш удаа олгохоор заажээ.

Үүний дагуу уул уурхайд ажиллаж байгаад хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтанд тухайн ажил олгогчоос нөхөн төлбөр олгодог бөгөөд өргөдөл гаргагчдын ажиллаж байсан Налайхын уурхай 1989 онд татан буугдсан тул Хөдөлмөрийн тухай хуулийн 97.4-т “Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг бүх шатны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой /51 буюу түүнээс дээш хувьтай/ хуулийн этгээд татан буугдсан, төлбөрийн чадваргүй болж дампуурсаны улмаас хариуцагчгүй болсон тохиолдолд ажилтанд олгох нөхөн төлбөрийн асуудлыг Засгийн газар, нутгийн захиргааны байгууллага тусгайлан шийдвэрлэж болно” гэж заасны дагуу дээр заасан нөхөн төлбөрийг төрөөс олгожээ.

Ингэхдээ Засгийн газрын 2001 оны 146, 2003 оны 65, 2004 оны 116, 2011 оны 116,

2012 оны 45 дугаар тогтоолоор үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болж хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдэд 5 удаагийн нөхөн төлбөрийг Засгийн газрын нөөц сангаас олгосон байна. Үүнд уул уурхайн салбарт ажиллаж байгаад тахир дутуу болсон иргэд хамрагджээ.

Эндээс үзэхэд аж ахуйн нэгж нь татан буугдсан иргэдэд төрөөс нөхөн төлбөрийг олгож байгаа хэдий ч энэ нь тогтмол олгохоор хуульд заагаагүй, нэг ба түүнээс удаа олгохоор заасан, практикт 1-7 жилийн хугацаанд зөвхөн нэг удаа 300 000 орчим төгрөг олгож байгаа нь уурхайчдын хөдөлмөрийн чадвар алдалт, өвчлөл, түүнд шаардагдах эмчилгээний зардалтай харьцуулвал харьцангуй бага байна.

Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөдөлмөрийн чадвараа алдсан иргэний хувьд нөхөн төлбөрийн асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасны дагуу зохицуулж байгаа бөгөөд хөдөлмөр эрхэлж байгаа, хөдөлмөрийн чадвараа алдсан иргэний хувьд нөхөн төлбөрийн асуудлыг Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд заасны дагуу хөдөлмөрийн чадвараа алдсан хувь, хугацаа зэргээс шалтгаалан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох замаар зохицуулж байна.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 1/42 тоот албан бичигт “Ахмад уурхайчдад гүнд ажилласны нэмэгдэл олгох нь нийгмийн даатгалын сангаас зарцуулах даатгуулагчийн өндөр наслах болон бусад эрсдлийг хуваалцах зохицуулалт биш тул улсын төсвөөс эсхүл тусгай сангуудаас ийм нэмэгдлийг санхүүжүүлэх нь зүйтэй юм. Түүнчлэн Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар уг сангаас төлбөр хэлбэрээр гаргуулах талаар судлах боломжтой.

Монгол Улсын хэмжээнд нийт 445 хуулийн этгээд уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж, 11 393 хүн ажиллаж байна.

2013 оны 1 сарын 1-ний байдлаар дээр дурдсан хуулийн заалтын дагуу газрын дор нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон нийт 397 тэтгэвэр авагч, үүнээс 83 хувь нь буюу 330 хүн 1995 оноос өмнө, 17 хувь нь буюу 67 хүн 1995 оноос хойш тэтгэвэр тогтоолгосон байна. Дээрх иргэдэд нэг хүнд 5 сая төгрөгийг /ойролцоогоор дундаж тэтгэвэр 273,8 мянган төгрөгийг 18 дахин өсгөсөн дүн/ нэг удаа олгоно гэж үзэхэд нийт 2 тэрбум төгрөгийн эх үүсвэл шаардлагатай тул энэ эх үүсвэрийг бүрдүүлэх асуудал тулгарч байна” хэмээн Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамнаас мэдээллэсэн.

Мөн “газрын дор нөхцөлөөр ажиллаж байгаад тэтгэврээ тогтоолгон авч байгаад нас барсан иргэдийн ар гэрт нэг удаагийн нөхөн төлбөр олгох асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй гэсэн саналтай байна. Энэ хүрээнд улсын төсвөөс нөхөн олговор олгох, эсхүл татварын хөнгөлөлтөд хамруулах замаар шийдвэрлэх гарц байна. Цаашид уг асуудлыг нэгдсэн бодлогоор шийдвэрлэх талаар Уул уурхайн яамтай хамтран ажиллаж, санал боловсруулан Засгийн газарт асуудал оруулах нь зүйтэй гэж үзэж байна” хэмээн дурджээ.

Түүнчлэн Уул уурхайн сайдын 2014 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн 1/1398 тоот албан бичигт “Эх орныхоо бүтээн байгуулалт, хөгжилд үнэтэй хувь нэмрээ оруулж явсан

ахмад уурхайчдын хөдөлмөрийг үнэлж, хүндэтгэн үзэж уул уурхайн салбарт хүнд, хортой нөхцөлд ажиллаж байгаад мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан уурхайчдад нэг удаагийн нөхөн төлбөр олгох тухай шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий Хөдөлмөрийн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Эрдэс баялгийн салбарын ахмадын нэгдсэн холбоо, Геологи, уул уурхайн нүүрс ассоциацийн төлөөлөл багтсан Ажлын хэсгийг байгуулж, нарийвчилсан судалгаа, нөхөн олговор олгох боломжийн талаар холбогдох яамдуудтай хамтран ажиллаж байна” хэмээн дурджээ.

Монгол Улсад уул уурхайн салбарт ажиллагсадын тоо цаашид нэмэгдэх хандлагатай байна. Үүнтэй холбогдон уурхайчдын нийгмийн хамгааллын асуудал тулгарах нь зайлшгүй тул эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Гадаадын зарим орны туршлагын талаар:

Гадаадын улс орнууд дахь уурхайчдын тэтгэврийн зохицуулалтыг судлан үзвэл ХБНГУ-ын Нийгмийн хамгааллын тухай кодексийн VI бүлгийн 40 дүгээр зүйлд зааснаар 40 наснаас хойш уурхайчнаар /газрын дор/ 10-аас доошгүй жил ажилласан, 25-аас доошгүй жил тэтгэврийн шимтгэл төлсөн бол нийтлэгээр тогтоосон хугацаа /өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас 65/-наас 5 жилийн өмнө өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрхтэй байхаар заажээ.

Түүнчлэн кодексийн VI бүлгийн 45.1-д зааснаар эрүүл мэндийн шалтгааны улмаас уурхайчны хөдөлмөрийг эрхлэх боломжгүй болсон, хөдөлмөрийн чадвар нь доройтсон нь эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон бол эрт /60 наснаас ч өмнө/ өндөр насны тэтгэвэр тогтоолгож болохоор заажээ.

Англид өндөр насны тэтгэврийн хэмжээ жил бүр автоматаар хамгийн багадаа 2,5 хувь нэмэгдэж байх зохицуулалттай.

ОХУ-ын Тэтгэврийн тухай хуулийн 27.1.11-д “Газрын гүнд ба ил уурхайд уурхайн үндсэн мэргэжлээр ажлын бүтэн өдрөөр 20-иос доошгүй жил ажилласан иргэний өндөр насны тэтгэврийг нас харгалзахгүй тогтооно” гэж заажээ.

2010 оны 4 дүгээр сард баталсан хуулийн дагуу уурхайд тодорхой мэргэжлээр ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон уурхайчдад “доплата” буюу нөхөн төлбөр нэмж олгодог бөгөөд **нүүрсний уурхайнууд улсын тэтгэврийн санд төлбөр төлж тусгайлан сан бүрдүүлэн тухайн сангаас нэмэлт нөхөн төлбөрийг өндөр насны тэтгэвэр тогтоолгосон уурхайчдад олгодог** байна. Сүүлийн үед нүүрсний уурхайнуудын төлбөр багасч, улмаар уурхайчдад олгох нөхөн төлбөр багасч байгаа ажээ.

Казахстан Улсын тэтгэврийн тухай хууль тогтоомжид зааснаар нийт 20-иос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил уурхайн хүнд ба хортой нөхцөлд ажилласан 53 нас хүрсэн эрэгтэй, нийт 15-аас доошгүй жил ажилласан, үүнээс 7,5-аас доошгүй жил хүнд ба хортой нөхцөлд ажилласан 48 нас хүрсэн эмэгтэй хүнд сар бүр улсын төсвөөс тусгай тэтгэмж олгодог байна.

“Сарын тооцооны үзүүлэлт /СТҮ/”-ийг нэгж болгон авч түүнийг хуульд заасан хэмжээгээр үржүүлж тусгай тэтгэмжийн хэмжээг тогтоодог байна.

Тэтгэмж авагч нь нийтлэгээр мөрдөх тэтгэврийн насанд хүрмэгцээ тэтгэврээ дахин тогтоолгох, эсхүл авч байгаа тэтгэмжээ үргэлжлүүлэхийн аль нэгийг өөрөө сонгох эрхтэй байна.

Украины хуульд тогтоомжид зааснаар “хүнд ба хортой нөхцөлд хамаарах мэргэжлээр ажиллаж байгаад хөдөлмөрийн чадвараа алдсан, уурхайн ослоор нас барсан уурхайчны ар гэрт орон сууцны нөхцөлийг сайжруулах, мөнгөн тусламжийг улсын төсвөөс олгохоор заасан. Түүнчлэн гүний уурхайд 15-аас доошгүй жил ажилласан уурхайчны их, дээд сургуульд элссэн хүүхдийн сургалтын төлбөрийг улсын ба орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр заажээ.

Хоёр. Санал, дүгнэлт

Иймд хүнд, хортой нөхцөл, газрын дор ажиллаж буй иргэдийн нийгмийн баталгааг хангах, тэдгээрт хөдөлмөрийн чадвар алдсаны нөхөн төлбөр олгох талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг судлан шаардлагатай тохиолдолд хуулийн төсөл боловсруулахыг Засгийн газарт чиглэл өгөх нь зүйтэй гэж үзэж байна.

Засгийн газар энэ талаар баримталж буй бодлого, улс орны эдийн засаг, нийгмийн онцлогт тохируулан оновчтой хувилбарыг сонгох шаардлагатай бөгөөд дараах асуудлуудыг анхаарах нь зүйтэй. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдэд олгох нөхөн төлбөрийг ажиллаж байсан ААН нь татан буугдсан тохиолдолд төрөөс хариуцаж болохоор заасан бөгөөд олгохгүй ч байж болохоор байна. Мөн олгох давтамжийн хувьд тодорхой бус байгааг анхаарах;
- Эдгээр иргэдийн хувьд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход энгийн нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгож буй иргэдтэй адил хувь хэмжээтэй /хугацаа нь 5-10 жилийн өмнө боловч/ байгааг эргэж харах;
- Төрөөс хариуцах дээрх нөхөн төлбөрийн эрсдэлийг тооцож, газрын дор болон хүнд, хортой нөхцөлд ажиллаж буй иргэдийн хувьд байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэх боломжтой эсэхийг судлах.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.ГАНБААТАР, С.ОДОНТУЯА, М.ЭНХБОЛД